ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 27 өдөр Дугаар 16/02 Арвайхээр сум

Хөрөнгө актлах, балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дах заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 24/02 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон Хужирт сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 438,500,898.72 (дөрвөн зуун гучин найман сая таван зуун мянга найман зуун ерэн найман төгрөг далан хоёр) төгрөгийн балансын үнэтэй, 330,077,428.51 (гурван зуун гучин сая далан долоон мянга дөрвөн зуун хорин найман төгрөг тавин нэг) төгрөгийн үлдэх өртөгтэй барилга, хайсан хашааг акталж данснаас хассугай.
2. Акталсан барилга, байгууламжийн 6211000263 нэгж талбарын дугаартай 1040 м2 талбайтай 2,080,000 (хоёр сая наян мянга) төгрөгийн үнэлгээ бүхий биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Хужирт сумын Засаг даргын Тамгын газарт балансаас баланст шилжүүлсүгэй.
3. Хөрөнгийн буулгалтын ажлыг зохион байгуулж, газар чөлөөлөх асуудлыг Хужирт сумын Засаг дарга (Ж. Оюунгэрэл)-д даалгасугай
4. Хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандартын дагуу бүртгэх ажлыг зохион байгуулах, хөрөнгийн хөдлөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд бүртгүүлэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ДАРГА Т.НАРАНГАРАВ

ИТХ/nuuts2026/1.togtool/togtool.doc